

дүүргийн ТҮК 1 болон 3-р хороонд өнгөрсөн 9-р сард дуудлагаар хог ачиж цуглуулах тогтолцоог явуулж эхэлсэн. Улмаар ТҮК энэхүү тогтолцоогоо хогны бункертэй өндөр байрууд болон том аж ахуй нэгжээс бусад үлдсэн зорилтод бүсүүдэд өргөжүүлсэн.

Дуудлагын тогтолцоог нэвтрүүлж эхэлснээс хойш хэдийгээр орчны нөхцөл байдал сайжирсан боловч хог ачих цагийн хуваарь тогтворгүй, хог хаягч нартай ямар нэг журам байхгүй байсны улмаас хогийн цэгүүд алга болоогүй байсан. Олонхи оршин суугчид болон жижиг аж ахуй нэгжүүд хог ачих цагийн хуваарийг хамаарахгүйгээр ойролцоох хуучин байсан контейнерын суурин дээр ил хогоо хаядаг болсон байсан. Зарим газарт оршин суугчид хог ил хаях шинэ цэг үүсгэсэн байсан. Үр дүнд нь хог ил хаях цэгүүд төслийн бүсэд ихээр үүссэн байсан бөгөөд улмаар энэ нь хог ачих ажилчдад хүндрэл учруулж цагийн хуваарийг алдагдуулж байсан. Мөн салхитай өдрүүдэд байрнуудын ойр орчмоор хог хийсч тархан хөглөрдөг байсан. Орчны нөхцөл байдлыг цэвэр байлгахын тулд ТҮК төслийн бүс нутгийн ихэнх хэсэгт хог ачиж цуглуулах үйлчилгээг өдөрт хоёр удаа явуулах болсон байсан. Эдийн засгийн нөхцөл байдлын үүднээс авч үзвэл энэ нь цаашид Хотын захиргаа хог ачиж цуглуулах үйлчилгээг өдөрт хоёр удаа үргэлжлүүлэн явуулах нь бараг боломжгүй зүйл юм.

Өмнөх контейнерын тогтолцооны нөхцөл байдал (2005 оны 3-р сар)



Өмнөх хог хаях цэг

Дуудлагын тогтолцоотой үеийн нөхцөл байдал (2006 оны 5-р сар)



Хуучин контейнер байсан газар



Хуучин контейнер байсан газар



Оршин суугчдын шинээр бий болгосон шинэ хогийн ил цэг



Хог ачих одоогийн нөхцөл байдал

Зураг 6-53: Хог хаях ил цэг болон төслийн хамрагдах хүрээнд хог ачиж байгаа нь Улаанбаатар хотод ЗР –ийг дэмжихийн тулд судалгааны баг төлөвлөгөөт бүсэд ангилан ялгах тогтолцоог хэрэгжүүлэхийг мастер төлөвлөгөөнд санал болгосон. Дээр дурьдсанчлан хог ачиж цуглуулах тогтолцооны хог ачих хуваарь нь тогтмол бус болон

оршин суугчид хүссэн үедээ хогоо хаядаг байсан. Ангилан ялгах тогтолцоог нэвтрүүлэхийн тулд хог ачиж цуглуулах үйлчилгээний хуваарийг тогтмолжуулах болон хог хаях журам мөрдүүлэх шаардлагатай байсан. Иймд Хотын захиргаа болон судалгааны багийнхан ангилан ялгах тогтолцоог хоёр үе шаттайгаар нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

## **в. Зорилго**

Туршилтын төслийн энэ хэсэгт ангилан ялгах тогтолцооны боломжыг нягтлахад чиглэгдсэн. Дээр дурьдсанчлан төсөл хоёр үе шаттай хэрэгжсэн бөгөөд хэсэг тус бүрийн зорилгуудыг доор дурьдав.

1- дүгээр үе шат:

- Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах (хог ачих хуваарийг тогтмолжуулах)
- Хог хаях журам нэвтрүүлэх

2-р үе шат:

- Ангилан ялгах тогтолцооны боломжийг нягтлах

## **с. Үндсэн арга зам**

Үндсэн арга замыг доор нэгтгэн дүгнэв.

### **с.1 Төслийн хүрээ**

Дээр дурьдсаны дагуу төсөл нь хоёр хэсгээс бүрдэнэ: (1) хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах (2) ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх. Нэгдүгээр үе шат нь мөн хоёр хэсэгт хуваагдана: (1) хог ачиж цуглуулах тогтолцоог өөрчлөх (2) хог хаях журам нэвтрүүлэх

### **Нэгдүгээр үе шат**

- Хог ачиж цуглуулах тогтолцоог өөрчилснөөр хог хаях журмыг нэвтрүүлж чадна.
- Хог хаях журам нэвтрүүлэх

### **Хоёрдугаар үе шат**

- Ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлж боломжыг судлах

### **с.2 Зорилт**

Бидний гол зорилт нь айл өрхийн хог ачиж цуглуулах тогтолцоо юм.

Дээр дурьдсанчлан төслийн хамрагдах хүрээ нь худалдааны болон оршин суугчдын орон сууцны барилга холилдсон бүс нутаг юм. Төслийн зорилтод барилгууд нь орон сууцны байрууд бөгөөд айл өрхөөс тусдаа хогоо ачуулдаг албан байгууллага болон том их дэлгүүрүүд нь зорилтод барилгаас хасагдсан.

Мөн хэдийгээр удаан хугацаанд судалгааны баг энэ тогтолцоог эцэс болгох нь илүү зохимжтой гэж үзэж байсан ч хогны бункертэй байруудыг зорилтод барилгаас хассан.

### **с.3 Холбогдох байгууллагуудын үүрэг, хариуцлага**

Хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоонд олон байгууллагууд татагдан холбогдсоноос хойш холбогдох байгууллага тус бүр төслийг саадгүй хэрэгжүүлэхийн тулд өөр өөрийн үүрэг, хариуцлагатай болсон бөгөөд тус бүрийнх нь үүрэг, хариуцлагыг доор нэгтгэн дүгнэв.

Хотын захиргаа болон ЖАЙКА-гийн судалгааны баг

- ✓ Хог хаях журмын төсөл боловсруулах (Журмыг хорооны Засаг дарга болон СӨХ-тэй хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ)
- ✓ Олон нийтийн ухамсарыг дээшлүүлэх болон шинээр нэвтрүүлэх хог хаях журмыг өргөн мэдүүлэхийн тулд сурталчилгааны материал бэлтгэх

Хорооны Засаг дарга

- ✓ Хорооныхоо нутаг дэвсгэр дээрх хогийн ил задгай цэгийг устгах санаачлага гаргах
- ✓ Хог хаях журмыг нэвтрүүлэхэд СӨХ—үүдэд дэмжлэг өгөх
- ✓ Олон нийтийн ухамсарыг дээшлүүлэх
- ✓ Хэрэв зарим аж ахуй нэгжүүд, эсвэл хэн нэгэн удаа дараа хуучин хогийн цэг байсан газарт хууль бусаар хогоо хаясаар байвал торгох

ТҮК

- ✓ Хог ачиж цуглуулах үйлчилгээгээ сайжруулах: Хог ачих цагийг баримтлах, хог ачих ажлын дараа ямар нэгэн хог үлдээхгүй байх, хурдан түргэн хог ачих ажлыг гүйцэтгэх гэх мэт
- ✓ Аж ахуй нэгжүүдтэй тохиролцоо, гэрээ хийх.(хэрэв шаардлагатай бол аж ахуй нэгж бүртэй дахин гэрээ хийх)
- ✓ Аж ахуй нэгжүүдийн хог хаях байдлыг хянаж, шаардлагатай бол заавар танилцуулга өгөх

СӨХ

- ✓ Хог түр тавих цэгийг тогтоох
- ✓ Сурталчилгааны материал тараах
- ✓ Айл өрхүүд болон жижиг дэлгүүрүүдэд хог хаях журмыг танилцуулах
- ✓ Хог түр тавих цэгийг цэвэр байлгах
- ✓ Оршин суугчдын хогоо хаяж байгаа байдлыг хянаж, шаардлагатай бол тэдэнд заавар өгөх

Оршин суугчид болон аж ахуй нэгжүүд

- ✓ Орчноо цэвэр байлгахад СӨХ-дөө туслах
- ✓ Журмыг дагаж мөрдөх

**с.4 Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах үе шат**

Үе шат бүрийн дагуу явцыг нэгтгэн дүгнэв.

**с.4.1. Нэгдүгээр үе шат: Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах**

**(1) Хог ачиж цуглуулах тогтолцоог өөрчлөх**

Хог хаях журмыг нэвтрүүлэхийн тулд зарим нэгэн өөрчлөлт хийх шаардлагатай байсан. Шаардлагатай өөрчлөлтийг доор дурьдвал.

**Орчноос хог ачих тогтолцоо**

Туршилтын төсөл хэрэгжүүлэхийн өмнө хогны машин хуучин контайнер байсан газарт нийтийн хог хаядаг цэг дээр зогсож хог ачдаг байсан. Шинэ тогтолцооны хүрээнд хогны машин орон сууцны байр бүрийн орц болгоны үүдэнд зогсож хог ачна. (Орчноос хог ачих тогтолцоо). Нөгөөтэйгүүр хогны машин шинэ тогтолцооны дагуу илүү олон удаа зогсож хог ачна.

**Хог ачиж цуглуулах үйлчилгээний давтамж**


Туршилтийн төсөл хэрэгжүүлэхийн өмнө Чингэлтэй дүүргийн ТҮК орон сууцны айлуудын хогийг ачих үйлчилгээг өдөрт хоёр удаа үзүүлдэг байсан. Туршилтын төслийн хүрээнд айл өрхийн хогийг ачиж цуглуулах үйлчилгээний давтамж долоо

хоногт гурван удаа болж буурсан бөгөөд харин аж ахуй нэгжийн хогийг өдөр бүр ачдаг давтамжыг хэвээр хадгалсан.

Төслийн хамрагдах хүрээг А-бүс болон В-бүс гэсэн хоёр бүс хэсэгт хуваасан ба хоёр бүсийн хог ачих өдрийн хуваарийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6-74: Хог ачих өдрүүд

	А бүс	В бүс
Хороо	2 болон 3-р хороо	1 болон 4-р хороо
Ачих өдрүүд	Даваа, Лхагва, Баасан	Мягмар, Пүрэв, Бямба



Зураг 6-54: Бүс нутгуудын хог ачих өдрүүд

### Хог ачиж цуглуулах хуваарийг тогтмолжуулах

Хог ачиж цуглуулах үйлчилгээний хуваарь нь тогтмол байна. Хогны машин ихэнхдээ өглөөний 9:00 цагаас хог ачих үйлчилгээгээ эхэлнэ.

### Аж ахуй нэгжийн хогийг айл өрхийн хогноос тусад нь ачих

Туршилтийн төсөл хэрэгжүүлэхийн өмнө аж ахуйн нэгж болон айл өрхийн хогийг хамтад нь ачдаг байсан нь хог ачиж цуглуулах үйлчилгээ үр ашиг багатай байх хамгийн гол шалтгаан юм. Төслийн хүрээнд аж ахуй нэгжийн хогноос айл өрхийн хогийг тусад нь ачна.

### Хог хаягдлыг дуудлагаар ачиж цуглуулах тогтолцоо



Дуудлагын тогтолцооны чанга яригч ба дуу өсгөгчийн систем

Өөрчилсөн хог ачих тогтолооны хүрээнд оршин суугчид хогоо тусгайлан заасан газарт (энэ нь орон сууцны барьсан бүтцээс хамаарна) тавих, эсвэл хогны машинд шууд аваачиж өгч болно.

Мөн зорилтод бүс нутагт өөр нэг үйлчилгээ болох дахин ашиглагддаг хог хаягдал ачих үйлчилгээг явуулсан. Төслийн хүрээнд хэрэглэхээр 5 ширхэг дуу өсгөгч болон чанга яригч Япон улсаас худалдан авч төслийн бүсэд явах хогны машинд суулгасан. Энэ төхөөрөмж нь “Оумано Ояко” болон “Акатонбо” гэсэн хоёр төрлийн Япон аялгууг дуугарагддаг. Мөн микрофон хэрэглэх боломжтой.

Доор үзүүлсний дагуу ямар төрлийн хог ачих гэж байгаагаас хамаарч хоёр төрлийн аялгууг тавьж байхаар төлөвлөсөн.

Эх үүсвэр	Хог хаягдлын төрөл	Аялгуу
Оршин суугчдын хог хаягдал	Дахин ашиглагдахгүй хог хаягдал	2 “Оумано Ояко”
	Дахин ашиглагдах хог хаягдал	1 “Акатонбо”
АНН-ийн хог хаягдал	Дахин ашиглагдахгүй хог хаягдал	2 “Оумано Ояко”
	Дахин ашиглагдах хог хаягдал	1 “Акатонбо”

Дуут аялгууг тавихдаа анхаарах зүйлс нь:

- Зөвхөн хог ачих үедээ дуут аялгууг тавих.
- Хогны машиныг жолоодон явж байх үедээ дуут аялгууг тавьж болохгүй.
- Хүмүүсийн амгалан байдлыг алдагдуулахаар дуут аялгууг хэт чанга тавьж болохгүй бөгөөд дууны чангын хэмжээг 3 дээр тавьж байхыг зөвлөж байна.

Дуут аялгууг тавих үед доорх үр нөлөөтэй.

- Оршин суугчид болон жижиг аж ахуй нэгжүүдэд ирснээ мэдэгдэнэ.
- Тэдгээрийн хогийг ачиж байгаагаа батлана.
- Хог ачсаны дараа дараагийн өдөр хог ачих хүртэл хогоо хаяж болохгүй гэдгийг нь мэдэгдэнэ.
- Найрсаг дуут аялгуу нь хог ачих ажиллагааны муухай төсөөллийг эерэг болгох бөгөөд хог ачих ажилд хүмүүсийг хамтран ажиллахад нь уриалах болно.

## (2) Хог хаях журмыг нэвтрүүлэх

Төслийн хамрагдах хүрээ нь хүн амын нягтшил ихтэй болон аж ахуй нэгж олон байгаагын улмаас төслийн хамрагдах хүрээний бүх хэсэгт нэгэн зэрэг хог хаях журмыг нэвтрүүлэх бараг боломжгүй байсан.

Хог хаях журмыг эхний ээлжинд бага хэмжээний газарт буюу 1-р хорооны зүүн хэсэг, 3-р хорооны хойд хэсэгт нэвтрүүлж эхэлсэн бөгөөд туршилтын төслийг цааш нь 1 болон 3 дугаар хорооны үлдсэн хэсэгт өргөжүүлэн тэлж, улмаар 2 болон 4 дүгээр хороонд өргөжүүлэн нэвтрүүлсэн.

Хог хаях журам нэвтрүүлэх үе шатыг хэсэг тус бүр дээр доор нэгтгэн үзүүлэв.

### Бэлтгэл ажил

1) Зорилтод бүс нутгийн суурь судалгаа

- СӨХ, айл өрх болон аж ахуй нэгжээс судалгаа авах
- Тухайн үеийн хог ачиж цуглуулах тогтолцоог шалгах



- Айл өрхийн болон аж ахуй нэгжийн тоо, орон сууцны байрны бүтэц, СӨХ болгоны үйлчлэгч, жижүүрийн тоо зэрэг мэдээллүүдийг цуглуулах
  - Газрын зургийг боловсруулж шинэчлэх
- 2) Хорооны Засаг дарга болон СӨХ-тэй тохиролцоо хийх
- Хог хаях журмыг саадгүй хэрэгжүүлэхэд хорооны Засаг даргын дэмжлэг болон идэвхтэй оролцоо маш чухал. Энэ нь СӨХ доорх журмыг дагаж мөрдөхийг оршин суугчдаас шаардах боломжийг бүрдүүлнэ.
- Хогийн ил задгай цэгнээс үүсэх хүндрэл, түүнийг шийдэх боломж, мөн төсөл хэрэгжүүлэхтэй, ялангуяа хог хаях журмыг нэвтрүүлэхтэй санал нэг байгаа эсэх талаар хорооны Засаг даргатай уулзах
  - Төслийг танилцуулах болон тухайн СӨХ-ийн ойр орчинд хогноос болж үүссэн хүндрэлүүд, тэдгээрийг шийдвэрлэх боломж зэргийг хэлэлцэхийн тулд зорилтод бүс нутгийн СӨХ нэг бүртэй уулзах.
  - Хог хаях журмыг тохирох эсэхийг хэлэлцэж, тэднээс төсөлтэй хамтран ажиллах эсэх талаар асуух
- 3) Хог хаях журмын төсөл боловсруулах
- Суурь судалгааны үр дүн болон хорооны Засаг дарга, СӨХ-тэй хэлэлцсэний үндсэн дээр хог хаях журмын төсөл боловсруулах
  - Хотын захиргаа, хороо болон СӨХ-тэй хэлэлцэх
- 4) Хог ачиж цуглуулах тогтолцоог өөрчлөх
- Хог хаях журам хэрэгжүүлж хог ачих тогтолцоог өөрчлөхөд ТҮК-тэй хамтарч ажиллана.
- 5) Сурталчилгааны материал бэлтгэх
- Мэдээллийн самбар (Зөвхөн айл өрхүүдэд)
  - Айл өрх болон аж ахуй нэгжүүдэд ухуулах хуудас  
1 дэх: Хог хаях журам хэрэгжүүлж эхлэхийн өмнөх мэдэгдэх хуудас.  
2 дах: Хог хаях журмыг нэвтрүүлж эхэлсний дараахан журмын талаар дэлгэрэнгүй тайлбарласан ухуулах хуудас
- 6) Хяналт хийх хүн сонгох
- Хогийн ил задгай хуучин цэг дээр хяналт хийх нь журам мөрдүүлэхэд маш чухал. Хяналт тавих хүн нь эрх мэдэл бүхий хүн байх нь илүү чухал.
- Хорооны Засаг даргаас хяналт хийхэд тохирох хүн олж томилохыг асуух (Хорооны байцаагч, хэсгийн дарга гэх мэт)
- 7) Анхны уулзалт
- Хорооны Засаг дарга болон СӨХ-ийн удирдах зөвлөлийн гишүүдийг урьж эхний уулзалтыг (хамгийн анхны уулзалт) зохион байгуулах
  - Хог хаях журмын төслийг танилцуулж, тэдэнтэй зөвлөлдөх
  - СӨХ бүрийн нөхцөл байдалд тохируулж журмыг өөрчлөх (журмын гол агуулга болох хог ачих давтамж нь өөрчлөгдөхгүй байх бөгөөд хог түр тавих цэг зэрэг зүйлүүдийг СӨХ нэг бүртэй зөвлөлдсөний үндсэн дээр өөрчлөнө)
- 8) Үйлчлэгч, жижүүрүүдтэй уулзах
- Хог хаях журам хэрэгжүүлж эхэлсний дараа үйлчлэгч, жижүүрүүд нь маш чухал үүрэгтэй. Хэрэв зарим нэг оршин суугч буруу цагт, буруу газар хогоо хаявал үйлчлэгч, жижүүрүүд өөр газарт тухайн хогийг хадгалах бөгөөд энэ нь бусад оршин суугчид

тухайн хог дээр хогоо нэмж хаяхаас сэргийлнэ. Үйлчлэгч, жижүүрүүдийн идэвхтэй дэмжлэггүйгээр хог хаях журмыг саадгүй нэвтрүүлэхэд маш хүндрэлтэй. Иймд тэд хог хаях журам нэвтрүүлэхийн өмнө хог ачиж цуглуулах шинэ тогтолцоо болон хог хаях журмыг сайтар мэдэх хэрэгтэй.

- Бүх үйлчлэгч, жижүүрийг цуглуулж уулзалт зохион байгуулах (олон СӨХ-үүдийн дунд нэг уулзалт зохиож болно)

9) Сурталчилгааны материалыг тараах болон байрлуулах

- Мэдэгдэх, ухуулах хуудсыг айл өрх бүрт СӨХ, аж ахуй нэгж бүрт ТҮК тараах
- Орон сууцны байр болгоны орц бүрт мэдээллийн самбар наах

10) Оршин суугчдын хурал болон айл өрхүүдээр орж уулзах

- Оршин суугчдын дунд байрных нь ойролцоох газарт уулзалт, хурал зохион байгуулах, эсвэл айл бүрээр орж уулзах (хорооны Засаг дарга болон СӨХ хариуцах )
- Хог хаях журмыг танилцуулж хэлэлцэх
- Санал болгож буй хог хаях журмын хэлэлцүүлгэ
- Шаардлагатай бол журмын өөрчлөлтийг хянах

### **Хог хаях журмыг хэрэгжүүлэх**

1) Хяналтын ажил

Хог хаях журам нэвтрүүлсний дараах эхний долоо хоног орчим төслийн хамрагдах хүрээнд, ялангуяа хуучин хууль бус, ил задгай хогийн цэг дээр хяналт хийсэн.

- Оршин суугчид хэрхэн хогоо хаяж байгааг хянах
- Аж ахуй нэгжүүд хэрхэн хогоо хаяж байгааг хянах
- Хогны машин хэрхэн хог ачиж байгааг хянах
- Хогийн ил задгай хуучин цэг дээр хог хаясан хэвээр байвал хэн хаяж байгааг олж тогтоохоор хянах

2) Сурталчилгааны ажил үргэлжлүүлэн хийх

Зарим оршин суугчид журмыг буруу ойлгосон, эсвэл сайтар ойлгоогүй байвсанд нэмэлт ухуулах материал бэлтгэж тараасан. Мөн цөөн тооны оршин суугчид журмыг үл ойшоон, журмын дагуу бусаар хогоо хаясаар байсан бөгөөд тэдгээрийн байдлыг өөрчлөхийн тулд сануулах хуудас бэлтгэж тараасан. Мөн зарим тохиолдолд хорооны Засаг дарга болон СӨХ оршин суугчдын хурлыг дахин зохион байгуулсан.

- Нэмэлт ухуулах материал бэлтгэх  
3 дахь болон бусад: Төслийн явцад хэрэв ямар нэг гэнэтийн асуудал тулгарвал өөр, бусад ухуулах материалыг бэлтгэнэ.
- Нэмэлт уулзалтыг зохион байгуулах

3) Хуулийн дагуу арга хэмжээ авах

Зарим оршин суугчид шинэ журмыг дагаж мөрдөхгүй, хогийн ил задгай хуучин цэг дээр, эсвэл орцон дотроо хогоо хаясаар байсан. Олон нийтийн ухамсаргүйн улмаас тэдгээр хүмүүсийг хянахад СӨХ-д хүндрэлтэй байсан.

Олон нийтийн дунд журам зөгчигчийг торгох эрхтэй хорооны Засаг даргын идэвхтэй оролцоо нь нөхцөл байдлыг өөрчилж чадаж байсан. Зарим газарт хорооны Засаг даргын орчноо цэвэр болгох хүсэл эрмэлзэл болон удирдлагын дүнд нөхцөл байдал аажмаар сайжирсан.

#### с.4.2. Хоёр дугаар үе шат: Ангиан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэх

##### Зорилгод айл өрх

Ангиан цуглуулах тогтолцоог зөвхөн Чингэлтэй дүүргийн 3-р хорооны Улсын их дэлгүүрийн хойд талын орон сууцны дөрвөн байранд нэвтрүүлсэн. Төслийн хамрагдах хүрээг хязгаарласан шалтгаан нь :

- Тэдгээр дөрвөн орон сууцны байрны оршин суугчид, СӨХ болон үйлчлэгч нар нь төсөлд маш сайн хамтрагч бөгөөд сайн ажилладаг.
- Төслийг тэдгээр орон сууцны байрнуудад хамгийн түрүүнд нэвтрүүлсэн байсан бөгөөд оршин суугчид нь шинэ хог ачиж цуглуулах тогтолцоонд хэвшсэн байсан. Иймд бид тэднийг дараагын шатанд бэлэн байгаа гэж үзсэн.

Ангиан цуглуулах тогтолцоог доор нэгтгэн дүгнэвээс:


Хүснэгт 6-75: Дахин ашиглагддаг хог хаягдлын төрөл

Зэрэглэл	Хамаарагдах төрлүүд	Ачиж цуглуулах өдөр
Ерөнхий хог хаягдал	Дахин ашиглагддаг хог хаягдлаас бусад	Даваа, Лхагва, Баасан
Дахин ашиглагддаг хог хаягдал	Шилэн лонх, хуванцар сав, цаас, лааз, металл, хуванцар	Бямба

Мастер төлөвлөгөөнд дахин ашиглагддаг хог хаягдалд шилэн лонхыг оруулаагүй байсан хэдий ч төслийн хүрээнд хамрагдсан СӨХ оршин суугчдаар ангиан ялгуулсан дахин ашиглагддаг хог хаягдлыг зарах нь үйлчлэгчид ашигтай учир шилэн лонхыг дахин ашиглагдах хог хаягдалд хамруулахыг шаардсан.

#### с.5 Хуваарь

Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах ажлын хуваарийг доор үзүүлэв.



\*СӨХ: Сууц өмчлөгчдийн холбоо